

ХАР ЯМААТЫН БНГ-ЫН ИРГЭДЭЭС 2014, 2016, 2018 ОНД АВСАН СУДАЛГААГ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газраас байгаль хамгааллын болон сургалт сурталчилгааны ажлыг төлөвлөх зорилгоор Хар Ямаатын БНГ-т орчны бүсийн 2 аймгийн 2 сум (Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Хэнтий аймгийн Баян-Овоо сум)-ын 93 иргэдээс 2014, 2016, 2018 онд судалгааг 100 иргэнээс авсаны Хэнтий аймгийн Баян-Овоо сумаас 70%-ийг, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас 30%-ыг тус тус авсан.

2014 оны суурь судалгаанд оролцогчдын 58 буюу 62.4% нь эмэгтэй, 35 буюу 37.6% нь эрэгтэй байсан нь хүйсийн харицаа нь харицангүй тэнцүү биш байдлаар хийгдсэн гэж үзэж байсан. Насны хувьд 40-44 насныхан 20.4% буюу дийлэнх хэсгийг эзлэж байна. 43,7% нь яг нөөц газар дотор амьдардаг иргэд байсан бол 36.6% БНГ-ын орчны бүсэд амьдардаг, 19.7% нь БНГ-т амьдардаггүй, хэлж мэдэхгүй байна, бусад гэсэн хариултыг иргэд өгсөн байна.


Харин 2016 оны судалгаанд оролцогчдын 42 буюу 42.4% нь эмэгтэй, 57 буюу 57.6% нь эрэгтэй байв. Насны хувьд 25-29 насныхан 21.4% буюу дийлэнх хэсгийг эзлэж байна. 53,6% нь нутгийн байнгын оршин суугч байсан бол 38,6% нь сумын төвийн буюу орчны бүсэд, 4.1% нь тус нутагт амьдардаггүй иргэд өгсөн.

Сүүлийн 2018 оны явцын судалгаагаар хүйсийн хувьд 50 иргэн буюу 50% нь эрэгтэй, 50 иргэн буюу 50% нь эмэгтэй иргэд байсан ба 41% буюу хөдөө, 41%-нь сумын төвд, үлдсэн 18% нь хөдөө буюу сумын төвд амьдардаг байна. Насны хувьд 30-34 насны 19 иргэн буюу 19%, 35-39 насны 17 иргэн буюу 17%, 40-44 насны 15 иргэн буюу 15%, 25-29 насны 13 иргэн буюу 13%, 50-54 насны 10 иргэн буюу 10%, 45-49 насны 9 иргэн буюу 9%, 20-24 насны 8 иргэн буюу 8%, 55 дээш насны 6 иргэн буюу 6%, 15-19 насны 3 иргэн буюу 3% буюу дийлэнх хэсгийг 30-34 насны иргэд эзэлсэн байна.

Нутгийн иргэдийн мэдлэг, хандлага, дадал зуршлын өөрчлөлтийн 4 үе шатны түвшинд 2014, 2016, 2018 онуудад мэдээллийг цуглуулсан бөгөөд санамсаргүй түүврийн хэлбэрийг ашиглан асуумж судалгааны аргаар хийлээ. Асуумжаар цугларсан мэдээллийг Arian Survey Pro 3.0 программыг ашиглан боловсруулав.

Мэдлэгийн түвшин

1. ТХГН-ын талаарх мэдлэгийн түвшинг тодорхойлох зорилгоор “Та Улсын ТХГН-ийн талаар хэр мэдлэгтэй вэ?” гэсэн асуултанд (2014 он) судалгаанд оролцогчдын 72,0% нь “багахан” гэсэн бол 14,0% нь “сайн”, 11,8% “мэдэхгүй”, 2,2% “маш сайн” гэж хариулсан нь ТХГН-ын талаар мэдлэг өгөх олон нийтэд сурталчилгааны ажил хийх шаардлагатай байгааг харуулсан. Зураг-1 харуулснаар 2016 оны судалгаанд оролцогчдын 22% нь “маш сайн” гэсэн бол 14% “сайн”, 59% “багахан”, 5% нь “огт мэдэхгүй” гэж хариулсан бол 2018 оны судалгааг авч үзвэл 39 иргэн буюу 39,4% нь дунд 36 иргэн буюу 36,4% нь сайн, 21 иргэн буюу 21,2% нь маш сайн, 3 иргэн буюу 3% нь огт мэдэхгүй гэсэн байна. Сүүлийн 2018 оны судалгааг 2016 оныхтой харьцуулж харахад ТХГН талаар мэдлэг “маш сайн” гэсэн хариулт 2016 оныхоос




Зураг 1

0,8%-иар буурсан боловч, сайн гэсэн хариулт нь 22,4%-иар өсч “багахан” болон “мэдэхгүй” гэж хариулсан оролцогчдын тоон үзүүлэлт 19,6% ба 2% буурсан байна.

Эндээс бидний хийсэн мэдээлэл сурталчилгааны ажил нь ТХГН-ийн талаарх мэдлэгийг олон нийтэд тодорхой хэмжээнд олгож чадаж байгааг харуулж байна.

2. Улсын ТХГН-ын талаар мэдлэгийн түвшинг нь тодорхойлох зорилго бүхий “Газар нутгийг Улсын




ТХ-д хамруулах нь ач холбогдолтой гэж үзэж байна уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчид газар нутгийг ТХ-нд хамруулах нь ач холбогдолтой гэж үзэж буй нь 2%-иар нэмэгдсэн байгаа бол “мэдэхгүй” 3% буурсан байна. ТХГН-ын үнэ цэнийг олон нийтэд таниулах, мэдэлээлэх талын ажил сайн хийгдэж байна гэж үзэж болохоор байгаа боловч цаашид сайн анхаарах хэрэгтэй нь мөн харагдаж байна. (Зураг-2.)

Зураг 2

3. Хэрэв газар нутгийг Улсын ТХГН хамруулах нь ач холбогдолтой бол яагаад? (Зураг-2.)


Газар нутгийг Улсын ТХГН хамруулах нь ач холбогдолтой гэж хариулсан хүмүүсээс учир шалтгааныг нь мэдэж байгаа эсэхийг нь илрүүлэх, тодруулах зорилгоор энэхүү асуулгыг тавьсан бөгөөд явцын судалгаануудын дүнг харцуулхад “УТХГН хамрагдсанаар байгаль эзэнтэй болж ирээдүй хойч үедээ өвлөгдөн үлдэнэ” гэж хариулсан оролцогчдын тоо 4,2%, “УТХГН хамрагдсанаар нутгийн иргэд янз бүрийн төсөл, хөтөлбөрт хамрагдах боломжтой болно” хэвээрээ байхад “мэдэхгүй” 5,3%, “УТХГН байгуулах нь олон улсын жишигт нийцсэн байгаль хамгааллын дээд хэлбэр” асуултад хариулсан иргэдийн тоо 1% буурсан үзүүлэлттэй байна.



Зураг 3

4. Хар ямаат УТХГН ямар ангиллынх вэ?(Зураг4)

2016 оны судалгааг 2018 оны судалгаагай харьцуулахад хар ямаатын БНГ ямар ангиллын УТХГН болох талаар “мэдэхгүй” гэж хариулсан тохиолдол явцын судалгаанууд дээр гараагүй байна. Харин “Хар ямаатын байгалийн нөөц газар” гэж зөв хариулсан оролцогчдын тоо 4,2% өссөн байна. Эндээс харахад тухайн УТХГ-ын ангилалын талаарх мэдлэг нэмэгдсэн байна.




Зураг 4

5. Хар Ямаатын БНГ-ын үнэ цэнэ, ач холбогдлын талаар иргэдийн мэдлэгийн түвшин ямаршуу байгааг тодорхойлохоор “Та Хар Ямаатын БНГ-ын үнэ цэнийн талаар хэр сайн мэддэг вэ?” гэсэн асуултад 2016 оны судалгаанд оролцогчдын 44% “дунд буюу тааруухан”, 24.0% “маш сайн”, 20% “сайн”, 12% “мэдэхгүй” гэж хариулсан байна.


2018 онд авсан судалгаагаар үнэ цэнийн талаарх мэдээлэл нь 26% нь сайн, 41 % нь маш сайн, 26 % нь дунд зэрэг, 7% нь мэдэхгүй гэсэн байна.

Эдгээр хариултыг харьцуулж харвал Хар ямаатын БНГ-ын талаар “маш сайн мэддэг” гэж хариулсан хүний тоо 2%, “сайн” 21%-иар тус тус өссөн байна. Мөн “дунд зэрэг буюу тааруухан” 18% “огт мэдэхгүй” 5% тус тус буурсан нь тухайн байгалын нөөц газрын талаарх мэдлэг олон нийтэд сайн хүрч байгааг харуулж байна.(Зураг-5)




Зураг 5

6. Хар ямаатыг яагаад УТХГ-т хамруулах болсон талаар иргэдийн мэдлэг ямар байгааг тодорхойлох зорилгоор “Хар Ямаатын БНГ-ыг ямар үндэслэлээр УТХ-т авсан вэ?” гэсэн асуултад 2016, 2018 оны явцын судалгаанд оролцогчдын хариултыг (Зурагт-6) харвал 12% байгалийн өвөрмөц хэв шинж, 17% байгалийн нөөцийг хамгаалах, 14% аялал жуулчлалыг хөгжүүлэх, 3% байгалийн нөөц баялагийг хамгаалах, 5% нутгийн иргэдийн аж амьдралыг сайжруулах, орон нутгийг хөгжүүлэх 1% судалгаа шинжилгээний төв болгох гэсэн хариултууд тус тус өссөн бол мэдэхгүй нь 3% буурсан байна.



Зураг 6


7. “Хар ямаатын БНГ-т ямар сумдууд хамрагддаг вэ?” гэсэн асуултад явцын судалгаанд оролцогчдын хариултаас харахад зөв хариулсан хүний тоо 6,1% буурсан байгаа бол мэдэхгүй гэсэн хариулт нь 1% өссөн байна.



Зураг 7


8. “Та Хар ямаатын БНГ-т байдаг ховор, нэн ховор зүйлүүдийг хэлнэ үү?” гэсэн асуултад 2016 оны явцын судалгаанд оролцогчдын 81% нь буга, 77% бор гөрөөс, 34% цэнэ тогоруу, 33% алтангагнуур,

12% хонин тоодог, 11% тул, 6% огт мэдэхгүй, 5% нь бусад гэж хариулсан байна. Аль алин дээр нь бор гөрөөс, буга хоёр хамгийн их хариултыг өгсөн байна. 2018 оны судалгаагаар ховор болон нэн ховор зүйлүүдийг нэрлэх гэсэн асуултанд 88 % нь буга, 81 % нь бор гөрөөс, 46 % нь алтангагнуур гэж хариулжээ.(Хүснэгт 8)



Зураг 8


9. Хар Ямаатын БНГ-т ямар сөрөг нөлөөллүүд байгааг тодорхойлох зорилгоор “Хар Ямаатын БНГ-т хамгийн ихээр хор хөнөөл учруулж байгаа зүйлүүд юу вэ?” гэсэн асуултыг нутгийн иргэдээс явцын судалгаагаар асуулаа. 2014 оны судалгаанд оролцогчдын олонх буюу 30.1% хууль бус агнуур, 23.7% түймэр, 18.3% бэлчээрийн талхагдал, 17.2% ямарч аюул занал байхгүй, 15.1% уул уурхай, 15.1% ахуйн хог, 15.1% байгалийн хүчин зүйл, 10.8% мэдэхгүй гэж хариулсан байхад 8.6% замбараагүй аялал жуулчлал, 6.5% бургасны зохисгүй ашиглалт, 5.4% хортон шавж, 2.2% хор хөнөөл аюул занал байгаа гэвч чухам юу вэ гэдгийг нь мэдэхгүй байна гэж хариулжээ. Тэгвэл 2016 оны явцын судалгаанд оролцогчдын 52% бэлчээрийн талхагдал, 45% түймэр, 31% байгалийн хүчин зүйл, 27% ахуйн хог, 20% уул уурхай, 19% хууль бус агнуурыг нэрлэсэн байна. Дээрх судалгааны дүнгүүдийг хархад “хууль бус агнуур” 1,3% буурсан боловч бэлчээрийн талхагдал 33,7%, түймэр 21,3%, байгалийн хүчин зүйл 15.9%, ахуйн хог 11.9%, уул уурхай 0,5% тус тус өсөлттэй гарч байна. 2018 оны судалгаагаар бэлчээрийн талхагдал 64 иргэн 64% нь бэлчээрийн талхагдал, 35 иргэн буюу 35% нь түймэр, 30 иргэн буюу 30 % нь байгалийн хүчин зүйл нөлөөлж байна гэж хариулжээ.



Зураг 9

10. Тэгвэл бидний иргэдээс олж мэдэхийг хамгийн ихээр хүсэж буй “Хар Ямаатын БНГ-т хууль бус агнуур, ашиглалт их байдаг гэж та бодож байна уу?” асуултад суурь судалгаанд оролцогчдын 43.0% нь сайн мэдэхгүй, 25.8% үгүй, 17.2% тийм, 14.0% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Харин явцын судалгаанд оролцогчдын 44% нь үгүй, 35% нь сайн мэдэхгүй, 14% тийм, 7% нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Хоёр судалгааны дүнгээс харахад Хар ямаатын БНГ-т хууль бус агнуур, ашиглалт их байдаг гэсэн хариулт өгч байсан иргэдийн хариулт 3,2%, сайн мэдэхгүй буюу эргэлзээтэй хариулт 8% багасч хууль бус агнуур болон ашиглалт огт байхгүй гэж үзсэн иргэд 18,2% өссөн үзүүлэлт харагдаж байна.

2018 оны судалгаагаар 47 иргэн буюу 47% нь сайн мэдэхгүй, 36 иргэн буюу 36% нь үгүй, 13 иргэн буюу 13% нь тийм, 4 иргэн буюу 4% нь огт мэдэхгүй гэж хариулжээ.




Зураг 10


11. Судалгааны дүнгээс олж харах гэсэн бидний бас нэг асуудал бол хууль бус үйл ажиллагааг ямар зорилгоор үйлдэж байгааг мэдэх үүднээс “Хар Ямаатын БНГ-т хууль бус үйл ажиллагаа гарч байгаа

гол шалтгааныг та юу гэж бодож байна вэ?” гэсэн асуулт асуухад суурь судлагаанд хамрагдсан нутгийн иргэдийн 45.7% нь мэдэхгүй гэж хариулсан байхад 16.3% аялал зугаалга, 16.3% хууль эрхзүйн мэдлэг дутмагаас, 8.7% хоол хүнсэндээ махыг нь хэрэглэх гэж, 6.5% орлого олохын тулд, 6.5% бусад гэсэн хариултуудыг өгсөн байв. Тэгвэл явцын судалгаанд хамрагдсан иргэдийн 36.4% нь мэдэхгүй гэж хариулсан бол 32,3% нь хууль эрхзүйн мэдлэг дутмагаас, 14.1% хоол хүнсэндээ, 9.1% аялал зугаалга, 6.1% орлого олохын тулд, 2% бусад гэж хариулжээ. Үүнээс хархад хоол хүнсэндээ хэрэглэх зорилготой хууль бус үйл ажиллагааны эзлэх хувь 5,4%, хууль эрхзүйн мэдлэг дутмагаас 16% тус бүр өссөн бол аялал зугаалга 7,2%, орлого олохын тулд 0,4%, бусад 4.5% үзүүлэлтүүд тус тус буурсан байна.

2018 оны судалгаанаас 50 иргэн буюу 50,5 % нь мэдэхгүй гэж хариулсан байна.



Зураг 11




Зураг 12

12. Бидний судалгааны дүнгээс олж харах гэсэн бас нэгэн асуудал бол иргэд БНГ-т хориглосон үйл ажиллагааг зөрчисөн тохиолдолд хүлээх хууль, хариуцлагын талаар мэдлэгтэй эсэх байлаа. Тэгвэл суурь судалгаанд оролцсон нутгийн иргэдийн 35.5% энэ талын ойлголт, мэдлэг байхгүй, 34.4% хууль дүрмийг мэдэх боловч хариуцлагын талаар мэдэхгүй, 14.0% ойлголттой боловч нарийн ширийн зүйлсийг мэдэхгүй, 8.6% хариуцлагын талаар мэдэх боловч хуулийн талаар мэдэхгүй, 5.4% хууль дүрэм болон хариуцлагын талаар сайн мэднэ, 2.2% бусад гэж хариулсан. 2018 оны судалгаанд


хамрагдсан нутгийн иргэдийн 10,4% нь хууль дүрмийг мэдэх боловч хариуцлагын талаар мэдэхгүй, 21,9% нь энэ талын ойлголт, мэдлэг байхгүй, 16,3% ойлголттой боловч нарийн ширийн зүйлсийг мэдэхгүй, 19,8% хариуцлагын талаар мэдэх боловч хуулийн талаар мэдэхгүй, 15,6% нь хууль дүрэм болон хариуцлагын талаар сайн мэднэ, 1% нь бусад гэж хариулав. Харин суурь судалгааг явцын судалгааны дүнтэй харицуулахад “хуулийн болон хариуцлагын талаарх ойлголт байхгүй” гэж хариулсан хүний тоо 13,6%, буурсан эерэг үзүүлэлттэй байна. Эдгээр дүр зургаас харахад орон нутгийн иргэдийн хуулийн талын мэдлэгт тодорхой ахиц гарч байгаа боловч цаашид холбогдох хууль, тогтоомж, хариуцлагын талаар цэгцтэй мэдлэг олгох шаардлагатай байна.

13. Улсын тусгай хамгалалттай газар нутгийн хилийн тэмдэгжүүлэлтийн талаарх иргэдийн мэдлэгийн түвшин хэр байгааг тандах зорилгоор дараах асуултыг асуулаа. Энэхүү асуултанд нийт суурь судалгаанд оролцогсодын 45,2% нь мэдэхгүй, 25,8% дунд зэрэг буюу тааруухан, 24,7% сайн, 4,3% маш сайн гэж хариулсан. Үүнийг явцын судалгаатай харьцуулахад маш сайн гэж хариулсан иргэд 27%, дунд зэрэг буюу тааруухан гэсэн хариулт 19,7% өссөн байхад сайн гэж хариулсан иргэд 6,5%, мэдэхгүй гэсэн хариулт 40,1% тус тус буурсан эерэг үзүүлэлттэй харагдаж байна. 2018 оны судалгаагаар 42 иргэн 45,2 % нь дунд зэрэг тааруухан, 33 иргэн буюу 34 % нь маш сайн, 18 иргэн буюу 18,6 % нь сайн 5 иргэн буюу 5,2% нь мэдэхгүй гэж хариулсан байна.



Зураг 13


14. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал нь иргэд байгальдаа эзэн болж, хамгаалж түүнээсээ ашиг олж амьжиргаагаа дээшлүүлэх таатай боломж юм. Орон нутагтаа үүн дотор Хар ямаатын БНГ-т аялал жуулчлалын ямар хэлбэр илүү хөгжвөл үр дүнтэй болох талаар тэдний санал, бодлыг сонирхлоо. Хоёр судалгааг харьцуулахад “нутгийн зан заншлийн аялал” хамгийн их санал авсан бол “эко аялал”, “морин аялал” удаах саналуудыг авсан байна. Явцын судалгаанд “мэдэхгүй” (суурь судалгаанд 15,1% байв) гэж хүн нэг хариулсан. Энэ нь орон нутгийн иргэд аялал жуулчлалын хэрэгцээ шаардлага, ашиг тусыг мэддэг болсонтой холбоотой.



Зураг 14

15. Нутгийн иргэд өөрийн нутагтаа байгаа ан амьтны тоо толгойн өсөж буурах явцыг хэр сайн мэддэг болохыг тодорхойлохоор “Бор гөрөөс танай нутагт элбэг уу?” гэсэн асуултыг нийт судалгаанд хамрагдсан иргэдээс асуухад суурь судалгаанд хамрагдсан иргэдийн 33.3% ховор, 30.1% цөөн тооны, 20.4% мэдэхгүй, 16.1% олон гэж хариулав. Харин явцын судалгаанд хамрагдсан иргэдийн 45.5% ховор, 23.2% олон, 16.2% цөөн тооны, 13.1% мэдэхгүй, энэ талаар бодож байгаагүй 2% гэж хариулсан байна.


2018 оны судалгаагаар 38 иргэн буюу 38,8 % нь ховор, 33 иргэн буюу 33,7 % нь цөөн тооны гэсэн хариулт өгсөн байна.



Зураг 15

16. Бор гөрөөсний тоо толгой буурахад хууль бус агнуур нөлөөлж буйг тодорхойлох зорилгоор “Бор гөрөөсийн хулгайн агналт их байдаг гэж та бодож байна уу?” асуултанд суурь судалгаанд


оролцогчдын 64.1% мэдэхгүй, 21.7% тийм гэж хариулжээ. Тэгвэл явцын судалгаанд хамрагдсан иргэдийн 45.5% мэдэхгүй, 41,4% үгүй, 13.1% тийм гэж хариулжээ. 2018 оны судалгаагаар 52 иргэн буюу 54,2 % нь мэдэхгүй, 35 иргэн буюу 36,5 % нь үгүй, 9 иргэн буюу 9 % нь тийм гэж хариулсан.



Зураг 16

17. Тэгвэл яагаад бөр гөрөөсийг хууль бус агналт явагдах болов гэдгийг тодорхойлохоор “Бор гөрөөс агнаж буй гол шалтгааныг та юу гэж бодож байна вэ?” асуултанд суурь болон явцын судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь эмчилгээний зорилгоор эд эрхтэнг нь хэрэглэх гэж агнадаг гэсэн бол 1-2,2% нь орлого олохын тулд агнадаг гэсэн хариулт 1,2%, ь зугаа цэнгэлээр агнадаг гэж хариулсан нь 0,4% хэдийгээр буурсан үзүүлэлттэй байгаа боловч хууль бус агналт явагдсаар байгаа нь харагдаж байна.


2018 оны судалгаагаар эмчилгээний зорилгоор 38 иргэн буюу 38,8 % нь эмчилгээний зорилгоор 35 иргэн буюу 35,7 % нь мэдэхгүй гэж хариулсан байна.



Зураг 17


18. Хэрлэн голын ус юунаас бохирдож байгаагааг тогтоох зорилгоор дараах асуултыг судалгаанд оролцогсодоос асуув. Уг асуултанд явцын судалгаанд хамрагдсан нутгийн иргэдийн 47.9% нь ахуйн хогноос, 34.4% хуулийн мэдлэг дутмагаас, 8.3% мэдэхгүй, 7.3% замбараагүй аялал жуулчлалаас, 2.1% бусад хүчин зүйлсээс гэж үзсэн бол суурь судалгаанд оролцогчдын 37.4% нь ахуйн хогноос, 22.0% хуулийн мэдлэг дутмагаас, 19.8% замбараагүй аялал жуулчлалаас, 13.2% мэдэхгүй, 7.7% бусад хүчин зэргээс харахад бид цаашид нутгийн иргэдэд чиглэсэн байгаль хамгаалах уламжлалт арга ухаан болон бусад хууль тогтоомжийн талаар сургалт сурталчилгааны ажлыг илүү түлхүү хийх хэрэгтэй гэдэг нь харагдаж байна.

2018 оны судалгаагаар 41 иргэн буюу 41 % нь маш их бохирдолтой, 39 иргэн буюу 39% нь бохирдолтой, 10 иргэн буюу 10% нь бага зэргийн бохирдолтой гэжээ. Тэгэхээр Хэрлэн голын усны бохирдол жил ирэх тусам ихэсч байна гэдэг нь ажиглагдаж байна.



Зураг 18


19. Бэлчээрийн талхигдалд гол нөлөөлж буй хүчин зүйлс юу болохыг тодорхойлох зорилгоор дараах асуултыг нутгийн иргэдээс асуулж тодрууллаа. Уг асуултанд суурь судалгаанд хамрагдсан иргэдийн 28.6% малын тоо толгой нэмэгдсэн, 26.4% бэлчээрийн зохисгүй ашиглалт, 15.4% бусад, 13.2% мэдэхгүй гэж хариулсан байхад явцын буюу 2014 оны судалгаанд хамрагдсан иргэдийн 61.2% малын тоо толгой нэмэгдсэн, 21.4% бэлчээрийн зохисгүй ашиглалт, 9.2% иргэдийн мэдлэг ухамсар муу гэсэн бол 2018 оны судалгаанд хамрагдсан иргэдийн 59,6 % нь малын тоо толгой нэмэгдсэн, 25,3 % нь бэлчээрийн зохисгүй ашиглалт гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд 2016 оныхоос 50%-иар малын тоо толгой нэмэгдсэн байна.



Зураг 19


Хандлагын түвшин

20. Хандлагын түвшинг тодорхойлохдоо бид хэсэг асуулт тавьсан бөгөөд тухайн асуултуудтай судалгаанд оролцогч хэр санал нийлж байгаад үндэслэлээ. “Бор гөрөөс болон бусад амьтдыг хууль бусаар агнасан ямар ч хүн хуулийн дагуу хариуцлага хүлээх нь зүйтэй” гэдэгтэй суурь судалгаанд оролцогчдын 82.4% нь санал нийлж байсан бол явцын судалгаанд энэ тоо 89,9% болж (7.5%-иар) өссөн байна. 2018 оны судалгаагаар санал нийлж байгаа гэж хариулсан иргэд 2%-иар, буурсан үзүүлэлттэй байна.




Зураг 20

22. Бэлчээрийн талхагдалд малын тоо толгойн өсөлт нөлөөлж байгаа учир малаа бэлчээрийн дацанд тохируулах хэрэгтэй” гэдэгтэй явцын 2016 оны судалгаанд оролцогчдын 89% нь санал нийлж байсан бол 2018 судалгааны энэ тоо 80,8% байгаагаас үзэхэд нутгийн иргэд малынхаа тоог бэлчээрийн дацандаа тохируулан өсгөх хандлага илүү байна.



Зураг 21

23. Замбараагүй аялагчид түймэр гарах нөхцөл, олон салаа зам гаргах, хог хаягдлыг бий болгодог” гэсэн асуултай 2018 оны судалгаанд оролцсон нутгийн иргэдийн 82,8 % нь санал нийлж байсан бол 2016 оны судалгаанд хамрагдсан нутгийн иргэдийн энэ тоо 89% байна. Үүнээс харахад нутгийн иргэд замбараагүй аялал жуулчлал сөрөг нөлөөтэй гэдэг хандлага 6,2% буурсан байна.




Зураг 22

Дадал заншилийн түвшин

24. Хар Ямаатын БЦГ-ын амьтан ургамлыг хамгаалах талаар дараах асуудлуудын аль нь таны үйл ажиллагаатай хамгийн их нийцэж байгааг тодорхойлох зорилгоор дараах асуултыг тавьсан юм. 2014 онд 30.8% нь “Би сүүлийн 6 сард БНГ-аас хулгайн анагнах болон энэ төрлийн хэрэг зөрчилд санаа зовон яаж бууруулах талаар бодож байгаагүй” гэсэн хариултыг өгсөн байна. Тэгвэл иргэдийн 29.7%-д нь эерэг хандлага төлөвшсөн байгааг “Би сүүлийн 6 сард БНГ-аас хулгайн ан агнах болон энэ төрлийн хэрэг зөрчлийг бууруулах талаар санаа зовж, бодож байсан боловч хараахан юм хийгээгүй байна” гэж хариултаас нь харж болохоор байна. Харин 3.3% нь “Би сүүлийн 6 сард тогтмол ажиглалт, эргүүл хийж хулгайгаар ан агнах нь ямар сөрөг үр дагавартай болох талаар бусад хүмүүст байнга хэлж байгаа” гэж хариулсан нь үнэхээр бахархууштай хариулт байлаа. Харин 2016 оныхтой харцуулахад “Би сүүлийн 6 сард БНГ-аас хулгайн ан агнах болон энэ төрлийн хэрэг зөрчлийг бууруулах талаар санаа зовж, бодож байсан боловч хараахан юм хийгээгүй байна” гэсэн эерэг хандлага 4% нэмэгдсэн байхад “Би сүүлийн 6 сард БНГ-аас хулгайн ан агнах болон энэ


төрлийн хэрэг зөрчилд санаа зовон яаж бууруулах талаар бодож байгаагүй” гэсэн сөрөг хандлага 7,3%-р буурсан байдалтай байна. Гэсэн хэдийч “Би сүүлийн 6 сард тогтмол ажиглалт, эргүүл хийж хулгайгаар ан агнах нь ямар сөрөг үр дагавартай болох талаар бусад хүмүүст байнга хэлж байгаа” хамгийн чухал асуултыг хариулж байсан иргэд 0,2%-р буурсан үзүүлэлттэй байгаа нь бидний явуулсан үйл ажиллагаа тасралтгүй динамик аргаар явж чадаагүйтэй холбоотой байх талтай. Цаашид бид үйл ажиллагаандаа нутгийн иргэдийг нутагтаа эзэн нь байж хамгаалалын олон талт үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажиллах нэн чухал байна.



Зураг 23

Бусадтай санаа бодлоо хуваалцах түвшин

25. Нутгийн иргэд өөрсдөө зэрлэг амьтан, гол ус, байгалийн нөөцөө хариуцан хамгаалах нөхөрлөл байгуулан байгалиа хамгаалах түвшинг тодорхойлохыг зорилоо. Хэдийгээр нөхөрлөл байгуулан байгалиа хамгаалах нь зүйтэй гэж хүлээн зөвшөөрч байгаа ч судалгаанд оролцогчдын 60.4% нь дээрх асуудлаар “хэнтэй ч яриагүй” гэж хариулсан ба явцын судалгаанд оролцогчдын хариулттай харцуулахад “хэнтэй ч яриагүй” гэсэн хариулт 16.5%-р буурсан байгаа нь бусадтай санал бодлоо хуваалцах, ямар нэг үйл ажиллагааг дэмжин оролцох үе шат руу шилжих бэлтгэл хангагдах шатандаа ойртож байна. Харин “хэнтэй ч яриагүй” гэсэн хариулт аль ч судалгаанд хамгийн өндөр/их хувийг эзлэж байна.




Зураг 24

Компанит ажлын үйл ажиллагаа болон мэдээлэл хүргэх арга зам

26. Хар ямаатын БНГ-ын болон Хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны талаарх мэдээллийг мэдээллийн ямар эх сурвалжаас авбал илүү үр дүнтэй болох талаар нутгийн иргэд саналыг авлаа. 2014 оны судалгаанд оролцогчдын хариултаас харахад 29.7% нь “зурагт хуудас”, 29.7% “товхимолууд” гэж үзсэн бол 23.1% “багийн нийтийн хурал, өдөрлөгөөс”, 15.4% “уулзалт, өдөрлөгөөс” хариулт өгч байсна бол 2016 оны судалгаанд оролцогчдын олонх нь 54.5% “байгаль хамгаалагчаас”, 21.2% “уулзалт, өдөрлөгөөс”, 17.2% “товхимолууд”, 15.2% “зарлалын самбараас” гэжээ.

Хоёр судалгаанд оролцогчдын хариултаас харахад давхардсан байдлаар хамгийн эхлээд “уулзалт, өдөрлөгөөс” гэсэн бол дараагаар нь бидний олон жилийн туршлагаар батлагдсан байгаль орчны мессежүүдийг өгөх хамгийн үр өгөөжтэй арга хэлбэр болох хэвлэмэл бүтээгдэхүүн “танилцуулга ном, брошур, зурагт хуудас” “зарлалын самбар” гэсэн хариултауд давамгайлсан байна. Иймд бид цаашид мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагааг явуулахдаа энэ талын арга замыг сонгон ажиллах хэрэгтэй.

2018 оны судалгаанаас авч үзэхэд 21 иргэн буюу 21,2% нь уулзалт өдөрлөгөөс, 20 иргэн буюу 20,2 % нь багийн иргэдийн нийтийн хурал, өдөрлөгөөс гэж хариулжээ.



Зүрэг 25